5-5

№. 8
х3 – х4

Хаягдал түүхий эдийг цуглуулах бас өөр арга байдаг. Сүүний картон хайрцаг болон хуванцар лонхыг албан байгууллага болон дэлгүүр дотор тусгай сав суурилуулж хүлээн авдаг.

Дэлгүүрийн өмнө байрлах тусгай хогны савнууд (Токиогийн төв)

Нагоя хот нэлээд өргөн хүрээтэй рисайкл хөтөлбөр хэрэгжүүлдэг хот юм. Тэнд хаягдал түүхий эдийг лонх, лааз, хуванцар лонх, гялгар уут болон цаасан уут гэж таван төрлөөр ангилдаг бөгөөд иргэд хогоо ялгаж тусгай цэг дээр холбогдох журмын дагуу хаях ёстой байдаг.



Хаягдал түүхий эдийг хэрхэн ялгаж хаях вэ (Нагоя хот)

Түүнчлэн ашгийн бус байгууллагууд байнга (сард хоёр удаа) Нагоя хотын нийт хэмжээнд хаягдал түүхий эд авах 42 цэгүүдийг дэлгүүр, супермаркетын машины зогсоол зэрэг газруудад нээн ажиллуулж 11 нэр төрлийн хаягдал түүхий эд авдаг байна.

Хаягдал түүхий эд авах цэг (Нагоя хот)

Хойд Америкийн рисайкл хөтөлбөр

Хойд Америкийн зарим хотууд нэлээд идэвхтэй рисайкл хөтөлбөр хэрэгжүүлдэг. Сан-Франциско хот сумын хамт 2010 он гэхэд хог хаягдлыг 75 хувьтай ялгах, 2020 онд тэрхүү хувийг 100 хувьд хүрэх зорилт тавьж "Шидэт Гурав" гэсэн нэртэй гурван төрлийн хогны сав ашигладаг цоо шинэ хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж байна. Тэрхүү хөтөлбөр нь энгийн рисайкл болон органик (бүх төрлийн хүнсний хаягдал оролцуулан) хаягдал ялгах хөтөлбөр бөгөөд оршин суугчид хог хаягдлыг хаягдал түүхий эд, шатах хаягдал болон бусад хаягдал гэсэн гурван төрлөөр ялгаж цэнхэр, ногоон, хар гэсэн гурван хогны саванд хаях шаардлагатай (Цэнхэр хогны саванд хаягдал бүхий л төрлийн түүхий эдийг цаашид нарийвчлан ялгалгүйгээр хаях боломжтой).

Бордооны түүхий эдийг цуглуулах үйлчилгээг тухайн нэг өрх эсвэл рисайкл үйлчилгээ авдаг нийтийн орон сууцны байрны иргэдийн саналын дагуу явуулдаг. Олон гэр бүл амьдардаг буюу нийтийн орон сууцны хувьд хэн нэгэн этгээд (тухайн байранд амьдардаг байр хөлслөгч, байрны эсвэл үл хөдлөх хөрөнгийн менежер) зохицуулах үүргийг гүйцэтгэхийг зөвшөөрсөн тохиолдолд бордооны түүхий эд цуглуулах үйлчилгээнд хамрагдаж болох юм байна. Тэрхүү иргэдийн санаачлага, рисайкл болон бордооны хөтөлбөрт идэвхтэй оролцох байдлыг хангах зорилгоор хөтөлбөрт хамрагдаж буй иргэдийн хаягдал түүхий эдийг хотын захиргаанаас үнэгүй ачдаг боловч бусад хог хаягдлыг гарах хэмжээн дээр нь үндэслэн төлбөрийг хураадаг байна (2003 онд нэг өрх дунджаар 19.94 ам.доллар байв). Тэрхүү систем нь нийтийн орон сууцны хэмжээнд ангилан цуглуулах тогтолцоог хэрэгжүүлэх томоохон төслийн нэг билээ.

2. Хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах - Хөгжиж буй орнуудын жишээ -

Хөгжиж буй орнуудын томоохон хотуудын хог хаягдал цуглуулах тогтолцоо хангалттай бус, үр ашиг муутай үйлчилгээнээс шалтгаалан хог хаягдал замбараагүй тархах хүндрэл бэрхшээлтэй тулгардаг. Түүнчлэн хог хаягдлын менежментийн талаар олон нийтийн мэдлэг ухамсар доогуур, хогоо хаях оршин суугчдын зуршил, байдал нь хог хаягдлыг татан зайлуулах ажлыг улам хүндрүүлдэг байна.

Дээрх хүндрэл бэрхшээлтэй тулгарч байгаа хотууд орчны эрүүл ахуйн нөхцөл байдлыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах зорилгоор хог хаягдал цуглуулах тогтолцоог яаралтай сайжруулах шаардлагатай байна. Манай судалгааны баг хөгжиж буй орнуудын хог хаягдал цуглуулах тогтолцоог сайжруулах талаар орон нутгийн засгийн газарт зөвлөмж өгөх талаар нэлээд туршлага хуримтлуулсан. Энэхүү мэдээллийн товхимлын дугаарт Камбодж болон Шри Ланка улсын жишээг танилцуулах болно. Тэдгээр орнуудад хог хаягдал хаях журам, цагийн хуваарь тогтоох тогтолцоо нэвтрүүлсэн хог хаягдал цуглуулах үйлчилгээг амжилттай сайжруулж чадсан гол хүчин зүйлс байсан.

Камбоджийн жишээ (Пномпень хот)

Камбодж улсын нийслэл болох Пномпень хот нь 1.2 сая хүн амтай. Хотын төв хэсэг нь орон сууц болон худалдаа, үйлчилгээний барилга байшин шигүү баригдсан, хүн амын нягтрал ихтэй бүс юм. Манай судалгааны баг 2003-2005 онд тэрхүү хотод хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах Улаанбаатар хотод хийж буй судалгаатай төстэй судалгаа хэрэгжүүлсэн. Судалгааны ажлын хүрээнд замбараагүй тархах хог хаягдлын асуудлыг шийдвэрлэх зорилгоор хог хаягдал хаях журам тогтоож хэвшүүлэх туршилтын төсөл хэрэгжүүлсэн.

Төсөл хэрэгжих газрын гол гудамжинд хог хаягдал замбараагүй овоолж хаясан байдал (Туршилтын төслийн өмнө)

Пномпень хотын төв хэсгийн хог хаягдлыг татан зайлуулах үйлчилгээг хувийн компани явуулдаг боловч тэрхүү компанийн хогны машины парк хуучирсан, байнга эвдэрдэг байдлаас шалтгаалан хог хаягдал цуглуулах үйлчилгээ тогтмол бус болж үр ашиг нь их муудсан байсан.

Туршилтын төслийн өмнөх хог ачилт

Нөгөөтэйгүүр, иргэд хогоо хаана ч хаях боломжтой бөгөөд ихэвчлэн хотын төв гудамжууд нь нийтийн хог хаягдал хаях цэг болсон. Улмаар хотын нийт хэмжээнд энд тэнд хогийн овоолон бий болж асуудлыг улам дордуулан хүндрүүлж байсан (том овоолон болсон хог хаягдлыг ачихад ачилт нэрт нэлээд урт хугацаа шаардлагатай). Хотын төв хэсэгт өдөр тутам хог хаягдал ачих үйлчилгээ байдаг боловч гудамж талбайд ил задгай хог ихээр үлдэж улмаар эвгүй үнэр гарах, хорхой шавьж үржих зэрэг бусад хүндрэл бэрхшээл бий болгодог.

Туршилтын төслийн хүрээнд Байгаль орчны яам болон манай судалгааны баг төсөл хэрэгжүүлэх хоёр газар сонгов (нэг газар нь хотын төв, нөгөө нь хотын зах). Тэрхүү хоёр газарт тус бүр ажлын хэсэг байгуулсан. Тэрхүү ажлын хэсэгт иргэд, бизнесийн байгууллага, Сангкат (хотын засаг захиргааны хамгийн бага нэгж), хог хаягдал цуглуулах үйлчилгээ явуулах компани болон БОЯ-ны төлөөлөгчид тус тус орж байв. Ажлын хэсгийн гишүүд хэд хэдэн удаа уулзалт хийсний дунд хог хаях журмын төслийг боловсруулав. Журмын төслийг иргэд, оршин суугчдын уулзалтын үеэр эцэслэн тохироон. Журмын гол агуулга:

- Хогоо зөвхөн өөрийнхөө гэрийн гадаа эсвэл шатны хажууд хаяна уу.
- Хогоо зөвхөн хог ачих өдөр, хогны машин ирэхийн өмнөхөн гаргаж тавина уу (хамгийн цаад талын хугацаа - хэдэн цагийн өмнө гаргах).
- Хогоо зөвхөн хогны сав эсвэл уутанд хийж хаяна уу. Хогоо газар хаяж болохгүй.

Нөгөөтэйгүүр, хог цуглуулах үйлчилгээ явуулдаг хувийн компани иргэдийн саналыг харгалзан анхан шатны хог цуглуулалтыг түрдэг тэргээр ачих хэлбэрт шилжиж цагийн хуваараа өөрчилсөн байна.

Хог хаях журмыг 2004 оны 7 дугаар сараас мөрдөж эхэлсэн. Пномпень хотод иргэд бие хэрхэн биеэ авч явах байдал, хэв журам тэр болгон хэрэгжихгүй байдаг тул дээрх журмыг мөрдүүлэхийн тулд Пномпень хотын захиргаанаас ихээхэн хүчин чармайлт гаргах шаардлагатай байсан. Иймд эхний долоо хоногт БОЯ болон Сангкатын холбогдох ажилтан нар хуучин хууль бус хог хаядаг газруудын дэргэд биеэр байнга зогсож иргэд, оршин суугчдын хог хаях байдлыг хянаж байв. Хэрэв оршин суугчид журмын бус байдлаар хогоо хаях гэж буй тохиолдолд шинэ журмаар хогоо яаж хаях талаар тайлбар, зааварчилгаа өгч байв.

Туршилтын төслийн дараах хог ачилт

Энд туршилтын төслөөс өмнө хогны овоолон байнга байдаг байсан

Туршилтын төслийн дараа хог овоо байхгүй болсон

Төсөл хэрэгжиж байгаа газар

Зарим иргэд, оршин суугчид шинэ журам, аргачлалыг тэр болгон ойлгохгүй, хуучин хэв маягаараа эхний хэд хоног хаяж байсан боловч бид нарын тооцож байснаас хамаагүй эрт икэнх иргэд тэрхүү шинэ журмыг хүлээн зөвшөөрсөн. Хог хаях журам мөрдүүлснээр гудамжны хог хаягдлын овоолон байхгүй болж улмаар төсөл хэрэгжсэн бүсийн эрүүл ахуйн нөхцөл байдал сайжирсан. Иргэд шинэ журмын ач холбогдлыг ойлгож цаашид ч тэрхүү журмын дагуу явах хүсэлтэйгээ илэрхийлсэн.

Шри Ланкийн жишээ (Бадулла хот)

2002-2003 онд Шри Ланкийн хатуу хог хаягдлын менежментийг сайжруулах ЖАЙКА-ийн судалгаа хийгдсэн. Улаанбаатар болон Пномпень хотын төсөлтэй харьцуулахад энэ удаа Шри Ланкийн хөдөө орон нутгийн хотуудыг зорилт болгон судалсан. 40,000 хүн амтай Бадулла хот нь судалгааны хүрээнд хамрагдах долоон хотын нэг бөгөөд Ува аймагт байрладаг.

Туршилтын төслийн өмнө хогтой байсан гудамж

ЖАЙКА-ийн судалгаа хэрэгжихээс өмнө тэрхүү долоон хот нь хог хаягдал замбараагүй тархах ноцтой асуудалтай тулгарч байсан бөгөөд судалгааны багийн хийсэн судалгааны үндсэн дээр Бадулла хотын байдал хамгийн хүндрэлтэй гэж тодорхойлогдсон. Хотын захиргааны зүгээс хатуу хог хаягдлын асуудалд анхаарал тавьдаггүй, боловсон хүчин болон тоног төхөөрөмжөөр хязгаарлагдмал, ажилтан, ажилчдын мэдлэг чадварын түвшин доогуур байдал тэрхүү хүндрэлтэй асуудлуудын гол хүчин зүйлс байсан.

Судалгааны төслийн явцад Бадулла хотын захиргааны ажилтан нар хатуу хог хаягдлын асуудлаар мэдлэг чадвараа дээшлүүлэх боломжтой болж улмаар асуудалд нэлээд нухацтай хандаж өөрсдийн хотын хөрөнгөөр 2 хогны машин худалдаж авах шийдвэр гаргав. Тэрхүү хүсэл эрмэлзлэлийг дэмжин судалгааны баг Бадулла болон бусад 6 хотуудад туршилтын төсөл хэрэгжүүлэхээр шийдвэрлэж Бадулла хотод тусгайлан зохицуулагч томилсон.

Туршилтын төслийн хүрээнд нийт долоон хотуудын хэмжээнд дуудлагаар хог хаягдал цуглуулах үйлчилгээг нэвтрүүлэхээр болсон. Мэдээллийн товхимлын 6 дугаарт хог хаягдлыг дуудлагаар цуглуулах тогтолцоог тайлбарлаж байсан бөгөөд тэрхүү тогтолцооны хүрээнд хогны машин нь орон сууцны хороолол орж хөгжим дугаргах бөгөөд оршин суугчид гэртээ хадгалаж байсан хог хаягдлыг машинд гаргаж ачдаг.

Эхний шатанд бид санал болгож буй төслийнхөө талаар, хэрэгжих хугацаа зэрэг асуудлын талаар улсын хэмжээнд хатуу хог хаягдлын менежементийн асуудал хариуцдаг орон нутгийн ажилтан (Ерөнхий менежер, Эрүүл мэндийн яам болон нийтийн эрүүл мэндийн асуудал хариуцсан байцаагч) нартай санал солилцож холбогдох байгууллагуудын үүрэг ролийг тодорхойлсон.

Түүнчлэн бид хатуу хог хаягдлын менежментийн хяналт хариуцдаг ажилтан, жолооч, ачигч нартай уулзаж төслийн төлөвлөгөөг танилцуулан тэдгээр хүмүүсийн саналыг авсан. Шинээр нэвтрүүлэх тогтолцооны талаар холбогдох ажилтан нар анхнаас нь бүрэн гүйцэд ойлголттой болох нь чухал тул судалгааны багийн зүгээс сургалт зохион байгуулж видео сурталчилгааны материал бэлтгэн үзүүлсэн.

Хог хаягдлыг дуудлагаар цуглуулах тогтолцоог амжилттай нэвтрүүлэхийн тулд Камбоджийн төслийн адилаар, оршин суугчид хүлээн зөвшөөрхүйц энгийн хог хаях журам тогтоох, хогны машины цагийн хуваарь гаргах зэрэг нь гол хүчин зүйлс байв. Орон нутгийн хот болгон судалгааны багийн дэмжлэгтэйгээр хог хаях журам тогтоосон. Түүнчлэн төсөл хэрэгжүүлэх газар, цагийн хуваарь, хогны машины маршрут хог ачих өдөр, цаг давтамж зэрэг асуудлуудыг шийдвэрлэсэн. Оршин суугчид өдөр тутам хог хаягдал ачих үйлчилгээ авах сонирхолтой байсан боловч өдөр болгон ачих шаардлагатай хэмжээний хог хаягдал гаргах өрх тэр болгон байхгүй байсан бөгөөд өдөр тутам хог ачих нь зардал ихтэй юм.

Хог ачих цагийн хуваарийг зарим нэг цагийн хэлбэлзэлтэйгээр зохион байгуулсан нь хот болгон өөрийн хуваарийг гаргаж мөрдүүлэх боломжийг олгосон юм.

Бадулла хот нь холбогдох журам зааврыг оршин суугчдад урьдчилан хүргүүлсний дараа 2003 оны 7 дугаар сарын 20-ноос сонголт хийсэн бусад туршилтын төслийг хэрэгжүүлж эхэлсэн. Төсөл хэрэгжих эхний өдөр хотын дарга хогны машиныг дагаж иргэдийг идэвхтэй хамтран ажиллахыг хүсэж байв.

Туршилт эхлээд тодорхой хугацаа өнгөрсний дараа хотын дарга хог хаягдлыг цуглуулах дуудлагын тогтолцооны үр ашгийг ойлгож захиргааны нийт ажилчдыг дайчлан хотын хэмжээнд хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Бадулла хот нь бага багаар тэрхүү тогтолцоог өргөжүүлж 11 дүгээр сар гэхэд судалгааны багийн дэмжлэг авахгүйгээр нийт хотын хэмжээнд амжилттай хэрэгжүүлж чадсан. Түүнээс хойш хотын захиргаа өөрсдөө дуудлагын тогтолцооны үйл ажиллагааг хангаж хотоо цэвэрхэн, ариун цэврийн байдлыг нь чанд сахиж байна.

Ува аймгийн нийт орон нутгийн хотуудын дунд зохион байгуулсан хатуу хог хаягдлын семинарын үеэр Бадулла хотын дарга өөрийн хотын туршлагын талаар тавьсан илтгэлийн дараа туршилтын төсөл хэрхэн хэрэгжүүлэх талаар бусад хотуудад техникийн туслалцаа үзүүлэх санал тавьсан. Түүнчлэн Бадулла хотын дарга бусад арга хэмжээний хүрээнд ч хатуу хог хаягдлын асуудлыг дурьдаж олон нийтийн мэдлэг ухамсарыг дээшлүүлэх талаар тодорхой ойлголттой болсон.

3. Нэмэлт мэдээлэл

ЖАЙКА-ийн судалгааны гуравдугаар үе шат энэ оны 4 дүгээр сараас эхлэн хэрэгжиж байна. Төслийн хэрэгжилтийн эхний хоёр үе шатны хүрээнд хогийн төвлөрсөн цэгийн байдлыг сайжруулах асуудалд түлхүү анхаарч ирсэн бол энэ удаа хог хаягдлыг цуглуулах тогтолцоог сайжруулахад анхаарал хандуулж туршилтын төсөл эхлүүлэх төлөвлөгөөтэй байна.

Өнөөдөр орон сууцны хорооллын хог хаягдлыг цуглуулах үйлчилгээний үр ашиг тааруухан байгаа тул үйлчилгээний чанарыг сайжруулахад хог хаях журам нэвтрүүлэх нь чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна. Шинэ туршилтын төслийн хүрээнд энэ оны 5 дугаар сард хотын төвийн зарим бусад хог хаях журам нэвтрүүлж туршиж үзэх болно. Туршилтын төслийн талаар дараагийн дугаарт дэлгэрэнгүй тайлбарлах болно.

Улаанбаатар хотын хатуу хог
хаягдлын менежментийг сайжруулах
Мастер төлөвлөгөө боловсруулах
ЖАЙКА-ийн Судалгааны баг
Улаанбаатар - 46, Бага тойруу,
Нийслэлийн төр захиргааны
байгууллагуудын 3 дугаар байрны
1203 тоот өрөө
Утас: 327128
Факс: 323128
Email: swm1@kkcub.mn
http://www.kkcub.mn/

Туршилтын төслийн дараа Бадулла болон хотын төв хэсэг дэх хог ачилтын байдал

№. 3
x1 – x2



2005.05

Мэдээллийн Тойм Дугаар 3

Монгол улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн судалгаа

Агуулга

1. Улаанбаатар хотод шинэ хогийн цэг байгуулах тухай
    1-1 Улаанчулуутын өнөөгийн нөхцөл байдал
    1-2 Шинэ хогийн цэгийг сонгосон байдал
2. Улаанбаатар хотын одоогийн болон ирээдүйн хог хаягдлын урсгал
3. Нэмэлт агуулга

1. Улаанбаатар хотод шинэ хогийн цэг байгуулах тухай

1-1 Улаанчулуутын хогийн цэгийн өнөөгийн нөхцөл байдал

(1) Байгаль Орчны асуудал

Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотод нэлээд хэдэн хогийн цэгүүд байдаг бөгөөд хамгийн том хогийн цэг нь Сонгинохайрхан дүүргийн 4-р хороонд оршдог Улаанчулуутын хогийн цэг юм.

Эдгээр хогийн цэгүүдийн ажиллаж буй өнөөгийн механизмын тогтолцоо нь хогийн цэг дээр хогоо ил задгай хаядаг явдал юм (Фото1-д үзүүлэв). Энэ тогтолцоо нь байгаль орчны хувьд их ноцтой асуудал үүсгээд байгаа жишээ нь хогийн цэгээс эвгүй үнэр үнэртэх, гал гарах г.м. Мөн түүнчлэн гялгар уут, тоос шороо, үнс зэрэг тэндгүй тараагдаж хаясан байдал нь ялаа, шумуул, хортон шавж үржих орчинг бий болгож байна (Фото 2-т үзүүлэв).

Хогийн цэгүүдэд гарч буй бас нэг асуудал бол зарим хогны машины жолооч нар хогийн цэгийн ойролцоо хогоо хууль бусаар хаяж байна (Фото 3). Дээрх асуудлуудын улмаас Улаанбаатар хотын хогийн цэгүүд орчин тойрондоо нэлээд хэмжээгээр нөлөө үзүүлж байна.

Нэн ялангуяа Улаанчулуутын хогийн цэгийн нөхцөл нэлээд хүнд байгаа тул Улаанбаатар хотын захиргаа тус хогийн цэгийн нөхцөл байдал, үйл ажиллагааг сайжруулахын тулд шаардлагатай арга хэмжээ авах нь тун чухал байгаа бөгөөд ингэснээр байгаль орчныг цаашид бохирдуулахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой юм.

Фото 1: Хог хаягдлыг ил задгай хаяснаар муудан улмаар эвгүй үнэр гарч ялаа, шумуул цуглараад байна.

Фото 2: Өвөлсөн хогноос олон төрлийн газ гардагаас метаны хий голлож байна. Уг хий нь хог гэнэт шатах нөхцөл нь болдог.

(2) Улаанчулуутын хогийн цэгт хэрэгжүүлэх туршилтын төсөл

Улаанбаатар хотын захиргаа Улаанбаатар хотын Хатуу Хог Хаягдлын судалгааны багтай хамтарч Улаанчулуутын хогийн цэгийг сайжруулах зорилгоор туршилтын төслийг 2005 оны 7 сараас эхлэн судалгааны 2 дахь үе шатны ажлын явцад хэрэгжүүлэхээр шийдээд байна. Тус туршилтын төсөл нь дараах үндсэн 3 хэсгээс бүрдэнэ.

- Автопүү суурилуулж хяналтын байр барина
- Улаанчулуутын хогийн цэг дээр нилээд хэдэн барилга байгууламжийн ажил хийгдэнэ. Үүнд: далан барина, далангаа тойруулж хашаа барина мөн бохир шингэн цуглуулах байгууламж хийнэ. Улаанчулуутын хогийн цэг дотор зам тавина мөн хогийн цэг дээр гарч буй хортой хийг зайлуулах тоног төхөөрөмж суурилуулна.
- Эрүүл ахуйн шаардлага хангасан ландфил бүхий хогийн цэг байгуулж хогоо нягтруулж хөрсөөр хучина.

Иймд уг туршилтын төслийг амжилттай хэрэгжүүлснээр хогийн цэгээс гарах эвгүй үнэр, гал гарах асуудлыг багасгах юм.

(3) Улаанчулуутын хогийн цэгийг ашиглах хугацаа

Улаанчулуутын хогийн цэгийн нөхцөл байдлыг сайжруулсан хэдий ч бас нэг авч үзүүштэй асуудал бол тус хогийн цэгийн ашиглалтын хугацаа нь ердөө бүтэн 3 жилийн хугацаанд ашиглах боломжтой гэсэн тооцоо гарсан. УБ хотын нийт 6 дүүрэгт үүсч буй хог хаягдлыг Улаанчулуутын хогийн цэгт хаядаг тул Хотын Захиргаа шинэ хогийн цэг байгуулах төлөвлөгөө гарган ажиллах нь чухал байна.

Иймд шинэ хогийн цэг байгуулах ажлын бэлтгэл үе шат болох хогийн эцсийн цэг байгуулахад оновчтой гэж үзсэн газрыг сонгох ажлыг хотын захиргаа аль болох хурдан эхлүүлэх хэрэгтэй байна.

Уг судалгааны ажлын хүрээнд хогийн эцсийн цэг байгуулах ажилд ЖАЙКА-ийн судалгааны баг туслах бөгөөд түүнчлэн ирээдүйн хогийн цэгийг сонгоход ч хамтарч ажиллах болно.

Шинэ хогийн цэг байгуулах ажлын хамгийн шийдвэрлүүштэй асуудал нь хогийн цэгийн байршлыг оновчтой сонгох түүний процедурын асуудал юм. Хогийн эцсийн цэгийг сонгоход янз бүрийн байгууллагын төлөөлөгчдийг өргөнөөр татан оролцуулсан бөгөөд байгаль орчин, нийгэм эдийн засгийн асуудлуудыг хэлэлцэн зөвшилцөх нь чухал байна. Хатуу Хог Хаягдлын судалгааны эхний хэсгийн ажилд хотын захиргаа судалгааны багтай хамтран шинэ хогийн цэгийг байгуулахад хамгийн тохиромжтой гэсэн газраа сонгохын тулд бага хурал, семинар зохион байгуулж орон нутгийн төлөөлөгчид, холбогдох бүхий л байгууллагын төлөөлөгчдийг өргөнөөр татан оролцуулж асуудлыг өргөн хүрээтэйгээр хэлэлцэж зөвшилцлийн замаар шийдсэн. Шинэ хогийн цэгийг оновчтой газар сонгохын тулд тус судалгааны хоёрдугаар бага хурал, анхны семинаруудыг зохион байгуулав.

Фото 3: Хогийн цэг хүрэх замд хууль бусаар хог хаясан байдал

- 6 боломжит газрыг сонгох — Удирдах зөвлөлийн 2 дугаар хурлаар (2005 оны 3 сарын 9-нд)
- ЖАЙКА-гийн баг эдгээр газрыг харьцуулж үзэн үнэлэв
- Хамгийн тохиромжит хувилбаруудыг шалгаж үзэх (анхан шатны зөвлөлдөөн) — Хоёрдугаар Бага хурлаар (2005 оны 3 сарын 11)
- Хамгийн тохиромжит хувилбаруудыг сонгох — Удирдах зөвлөлийн 3 дугаар хурлаар (2005 оны 3 сарын 20)
- Нийтэд үр дүнг мэдээлэх — Анхны Семинар дээр (2005 оны 3 сарын 26)

Зураг 1: Хогийн цэгийг сонгох үйл явц

1-2 Шинэ хогийн цэгийг сонгосон байдал

(1) Сонгох үйл явц

Хотын захиргаа судалгааны багтай хамтарч ирээдүйн хогийн цэг байгуулахад хамгийн тохиромжтой газруудыг сонгохдоо дараах үе шаттайгаар сонгосон юм. (Зураг 1)-д үзүүлэв. Эхлээд бид ирээдүйн хогийн цэг байгуулж болох 6 боломжит газруудыг сонгосон болно.

- Улаанчулуутын хогийн цэгийн хойно байрладаг Нарангийн Энгэр
- ХМК (Ханын Материалын Комбинат) хуучин барилгын материалд зориулан шавар авч байсан шаврын карьер
- Морин Давааны хогийн цэгийн урд талд байрлаж буй газар
- Налайхын урд хэсэгт байрладаг Баянгийн Хонхор
- Хуучин Дарь Эхийн хогийн цэгийн урд талд байрлаж буй Цагаан Даваа
- Хуучин Багануурын нүүрсний уурхайн ашиглаж байсан карьер

Хогийн цэг байгуулахад боломжтой гэж үзсэн зарим газруудыг зураг дээр тэмдэглэв.

(2) Хоёрдугаар бага хурлын үр дүн

Энэ удаад бидний зохион байгуулсан хоёрдугаар бага хурлын гол зорилго нь дэвшүүлж буй 6 боломжит газруудын байгаль орчин, эдийн засаг, нийгмийн асуудлуудыг судлан шинжлэх асуудал байна.

Хоёрдугаар бага хуралд доорх байгууллагын төлөөлөгчид оролцсон болно. Үүнд

- Яамдууд : БОЯ, ЗМЯ, ҮХЯ, СЯ
- Хотын захиргаа: ЗДТГ, ЗАА
- Дүүрэг: бүх дүүргийн захиргаа
- Нээц Компани болон дүүргийн ТҮК-ууд
- Хороодын засаг дарга нар, хогийн цэгээс сонгох боломжит газруудад ойрхон амьдардаг орон нутгийн иргэд болон
- Төрийн бус байгууллагын төлөөлөгчид.

6 боломжит газруудын талаар судалгааны багийн гишүүд илтгэл тавьж тус бага хуралд оролцогчдыг нийт 4 баг болгож хуваав. Багууд эдгээр 6 боломжит хувилбруудын байгаль орчин, бохирдол, нийгмийн, санхүүгийн дүн шинжилгээ зэрэг асуудлуудыг авч хэлэлцэн хогийн эцсийн цэг байгуулахад хамгийн тохиромжтой газрыг сонгохоор багууд хооронд хэлэлцэв. Багууд дээрх боломжит хувилбаруудыг дараах 5 шалгуураар нягтлан хэлэлцэв. Үүнд: (1) Ерөнхий нөхцөл байдал, (2) Зардал, (3) Нийгмийн нөлөөлөл, (4) Бохирдолын нөлөөлөл, (5) Ашиглах хугацаа.

Фото 4: Хоёрдугаар Бага хурал

Хуралд оролцогсод 6 боломжит хувилбаруудыг дээрх 5 шалгуураар 0-5 хүртэлх баллаар үнэлгээ өгч харьцуулан дүгнэж ярилцав. Зардал гэдэг шалгуурын хувьд 2010 он хүртэлх жил тутмын нийт зардлыг судалгааны багийнхан тооцож гаргаж индикатор болгон ашиглав. Судалгааны багийн хийсэн ажиглалтын судалгаанд үндэслэн хуралд оролцогсод боломжит хувилбруудын ашиглалтын хугацаанд үнэлгээ өгөв. Энэхүү хэлэлцүүлгийн эцэст баг тус бүр 3 боломжит хувилбаруудаас хогийн эцсийн цэг байгуулахад хамгийн оновчтой гэж үзсэн газрыг сонгож танилцуулав. Багуудын өгсөн үнэлгээнээс үзэхэд Нарангийн Энгэрийг хамгийн оновчтой гэж үзсэн.

Зураг 2: Боломжит газруудын байршил